

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 1/03


Чойр

Байгууллагын орон тоо, цалин сан
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 онд ажиллах төрийн захиргааны албан хаагчдын орон тоог 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны ажилчдын цалин санг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ДАРГА



Н.АЛТАНЦЭЦЭГ

4201210072

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын
2022 оны 02 сарын 15 өдрийн
8/03 тушаалын нэгдүгээр хавсралт

2022.02.15

№	Албан тушаалын ангилал	Овог нэр	Орон тоо
1	Дарга	Н.Алтанцэцэг	1
2	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор	Л.Одонтуяа	1
3	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, Дотоод аудитор	Э.Цэлмэгбаяр	1
4	Дотоод аудитор	-	2
НИЙТ			5

Жагсаалт гаргасан:

/Н.Алтанцэцэг/

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын
... оны ... сарын ... өдрийн
тушаалын хоёрдугаар хавсралт

2022.02.15

№	Албан тушаалын ангилал	Овог нэр	Ангилал зэрэглэл
1	Дарга	Н.Алтанцэцэг	T3-10-3
2	Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч	Л.Одонтуяа	T3-7-5
3	Дотоод аудитор	Э.Цэлмэгбаяр	T3-6-2
4	Дотоод аудитор	-	T3-6
5	Дотоод аудитор	-	T3-6

Жагсаалт гаргасан:

/Н.Алтанцэцэг/



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/39

Чойр

Санхүүгийн хяналт, дотоод аудитын
албаны дүрэм, бүтэц орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 65 дугаар зүйлийн 65.1.8, 69 дүгээр зүйлийн 69.1, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" 377 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/13 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга /Н.Алтанцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын 2015 оны "Санхүүгийн хяналт, аудитын алба байгуулах тухай" А/96 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

4212200153

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 сарын 11-ны өдрийн 1/39
дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг мөн.
- 1.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсөв санхүү, аудитын холбогдолтой хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, гэрээ болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хөтөлбөр, арга зүй, засаг даргын шийдвэр, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон мөрдөж ажиллана.
- 1.3 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны төсөв зардлыг аймгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.
- 1.4 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тогтоосон журмын дагуу хийгдсэн бэлгэдэл, тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба төрийн санд данстай байна.
- 1.5 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны батлагдсан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авна.

Хоёр. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааны зорилго

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангаж тухай байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Гурав. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага, зохион байгуулалт

- 3.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд аймгийн Засаг даргад ажлаа хариуцан тайлагнана.
- 3.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аудитын албаны дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор гэсэн бүтэц орон

тоотойгоор үйл ажиллагаа явуулна. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны орон тоо, цалингийн санг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулин дагуу жил бүр тогтоож, зардлыг тухай жилийн аймгийн төсөвт тусгана.

Дөрөв. Үйл ажиллагааны зарчим

- 4.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална.

Тав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 5.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь дараахь чиглэлтэй байна.
- 5.1.1 Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд хяналт шалгалт, аудит хийх
- 5.1.2 Төсвийн хөрөнгийн зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад аудит хийх
- 5.1.3 Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд аудит хийх
- 5.1.4 Төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, аудит хийх
- 5.1.5 Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдалд аудит хийх
- 5.1.6 Санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд хяналт шалгалт, аудит хийх
- 5.1.7 Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөлийн байдалд аудит хийх
- 5.1.8 Байгууллагын дотоод хяналтын болон засаглал, эрсдлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд аудит хийх
- 5.1.9 Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлан явуулах аудит
- 5.1.10 Холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит
- 5.2 Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцсэн, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан арга зүйн хүрээнд явагдана.
- Зургаа. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудиторын эрх үүрэг**
- 6.1 Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь дараахь эрхтэй байна.
- 6.1.1 Байгууллагын дотоод нэгж, хэсгүүдийн үйл ажиллагаатай танилцах
- 6.1.2 Холбогдох албан хаагчтай уулзалт ярилцлага хийх

6.1.3 Бичмэл болон цахим баримт мэдээлэл, материалыг газаргуулан авах, хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх

6.1.4 Шаардлагатай бол тухайн байгууллагын байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах

6.1.5. Санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай холбоотой баримт бичигтэй танилцах хүсэлт холбогдох банк, санхүүгийн байгууллагад тавих;

6.1.6. Өмнө хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэх;

6.1.7. Хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

6.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь дараахь үүрэгтэй байна.

6.2.1. Үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, олон улсын Дотоод аудитуудын институтээс гаргасан санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн болон дотоод аудиторын ёс зүйн дүрмийг чанд баримтлах;

6.2.2. Аудитын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;

6.2.3. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын явцад танилцсан, олж авсан бүх баримт бичиг, мэдээллийг зөвхөн хяналт шалгалтын болон дотоод аудитын үйл ажиллагаанд ашиглах;

6.2.4. Мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх;

6.2.5. Аливаа асуудалд шударга, бодит байдалд нийцүүлэн хандаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;

6.2.6. Аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар байгууллагын даргад мэдээлэх.

6.3. Дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь энэ журмын 6.1, 6.2-т зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1. Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах;

6.3.2. Хяналт шалгалтын танилцуулга, бусад баримт бичгийг (шалгалтын тэмдэглэл, нэг бүрчилсэн акт, албан шаардлага) зохих журмын дагуу үйлдэж, гарын үсэг зурах;

6.3.3. Хяналт шалгалтын тэмдэглэл, акт, албан шаардлагыг шалгуулсан этгээдэд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах;

6.3.4. Санхүүгийн хяналт шалгалтын болон аудитын материал, бичсэн танилцуулга, акт, тоо баримтын үндэслэл нотолгооны үнэн зөвийг хариуцах;

6.3.5. Шалгалтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

6.3.6. Санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.

Долоо. Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

7.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална.

7.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны жилийн төлөвлөгөөнд тусгасан хяналт шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагч батална.

7.3. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг холбогдох олон улсын стандарт, хууль, журмыг баримтлан гүйцэтгэнэ.

7.4. Улсын (ахлах) байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалтын дүнгийн талаар шалгалт дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор шалгалтын тэмдэглэл бичиж, байгууллагын даргад танилцуулна.

7.5. Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, дотоод аудитор нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.

7.6. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга дараах асуудлыг Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж тайлагнана:

7.6.1. Гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүн;

7.6.2. Байгууллагын жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц;

7.6.3. Холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц;

7.6.4. Хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц;

7.6.5. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал.

7.7. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалт, аудитын тайланг бэлтгэн байгууллагын даргад танилцуулна. Мөн Дотоод аудитын хороогоор тайланг хэлэлцүүлнэ.

7.8. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллана.

7.9. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хагас, бүтэн жилийн тайлангаа холбогдох газарт нь хуулийн хугацаанд хүргүүлнэ.

Найм. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын шалгалтын ажлын баримт

8.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг чанд баримтлах бөгөөд бүх үйл ажиллагааг баримтжуулна.

8.2. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, нэг бүрчилсэн акт, албан шаардлага, аудитын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний үе шат бүрийн явцын талаар зохих стандартын дагуу архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

Ес. Хөндлөнгийн аудиттай харилцах

9.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төрийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно.

9.1.1. Жилийн ажлын төлөвлөгөө, тайланг харилцан мэдээлэх;

9.1.2. Хамтарсан сургалт зохион байгуулах, арга зүй, туршлага харилцан судлах, солилцох;

9.1.3. Харилцан мэдээлэл солилцох.

---o0o---

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 сарын 11-ны өдрийн 1/39
дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

Д/Д	Байгууллагын нэр	Ажлын байр буюу албан тушаалын нэр	Ангилал, зэрэглэл	Орон тоо
1.	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Дарга	ТЗ	1
		Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор	ТЗ	4
		НИЙТ		5